



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ”ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар ХЭХ03/01


Улаанбаатар
хот

**Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд
хийсэн дүгнэлтийг батлах**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах зөвлөлийн хийсэн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:



Ц.ОТГОНБАЯР



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар ХЭХ03/02

Улаанбаатар
хот

Компанийн 2023 оны санхүүгийн төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.16 дах хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компанийн 2023 оны санхүүгийн төсөв, төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөлөөс хэлэлцүүлснийг хавсралтаар баталсугай.

2. 2023 оны санхүүгийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Ц.Отгонбаяр/, нягтлан бодогч Б.Алтанцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



Ц.ОТГОНБАЯР



“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар ХЭХ03/03

Улаанбаатар
хот

Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-23.3, 23.5-23.6, 24 дүгээр зүйлийн 24.1, 53 дугаар зүйлийн 53.1.1, 60 дугаар зүйлийн 60.3, 62 дугаар зүйлийн 62.1.4 дэх хэсэг заалтуудыг удирдлага болгон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын санал хураасан дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн ТУЗ-өөс боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсан компанийг өөрчлөх төслийг энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар уг компанийн хэлбэрийг өөрчилснийг баталсугай.
3. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар уг компанийн хэлбэр өөрчлөгдсөн ч компанийн өмнөх ТУЗ-ийн бүрэн эрхийг Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны бүртгэлээс хасах тогтоол гарах хүртэл хугацаанд үргэлжлүүлсүгэй.
4. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар уг компанийн хэлбэрийг өөрчилсөнтэй холбоотойгоор хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулах, хувьцааны үнэлгээ хийлгэх, брокерын болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй гэрээ байгуулах гэх мэт өөрчлөн зохион байгуулагдахад шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллах, ТУЗ-ийн нэрийн өмнөөс хийж гүйцэтгэх, төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Ц.Отгонбаяр/-т олгосугай.
5. Компанийг өөрчлөх замаар үүссэн компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах саналыг ТУЗ-д хүргүүлэх, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлээс хасуулах шийдвэрийг ТУЗ-өөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар гаргуулахыг гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Ц.Отгонбаяр/-д даалгасугай.
6. Өөрчлөн байгуулагдсан “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн эрх, үүрэг, хариуцлага шинээр бий болсон “Жуулчин Дюти Фрий” ХХК-д шилжиж байгаа болон хуулийн этгээдийн оноосон нэр, гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт ороогүй болохыг тус тус дурдсугай.
7. Өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нь өөрчлөн байгуулахын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй бол өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй болохыг дурдаж хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг хуульд заасны

дагуу зохион байгуулахыг гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Ц.Отгонбаяр/-т даалгасгай.

8. Энэхүү шийдвэрийг толгой компани болон холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх, бусад шаардлагатай ажиллагааг хийж гүйцэтгэхийг Баяраа овогтой Алтанцэцэг /РД:ЧА831230/, Батболд овогтой Бат-Эрдэнэ /РД:МЮ87081616/ нарт тус тус итгэмжилсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ОТГОНБАЯР



“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар ХЭХ03/04

Улаанбаатар
хот

Компанийн хэлбэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор дүрмийг шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1-д заасныг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ
НЬ:

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар өөрчлөн байгуулахаар шийдвэрлэснийг дурдсугай.

2. “Жуулчин Дюти Фрий” ХХК-ийн үйл ажиллагааны чиглэл дээр Татваргүй барааны дэлгүүр /3 жил/ үйлчилгээ эрхлэх чиглэлийг үргэлжлүүлэн Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлсүгэй.

3. Энэхүү тогтоолын 1 болон 2 дахь хэсэгт заасны дагуу “Жуулчин Дюти Фрий” ХХК-ийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар өөрчлөн байгуулах, татваргүй барааны үйл ажиллагааны чиглэлийг үргэлжлүүлэн бүртгүүлэхтэй холбогдуулан Компанийн дүрмийг хавсралт №1-ээр шинэчлэн баталсугай.

4. Энэхүү шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн Биржид хүргүүлэх, Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх, гэрчилгээ хүлээн ажиллагааг хийж гүйцэтгэхийг Баяраа овогтой Алтанцэцэг /РД:ЧА831230/, Батболд овогтой Бат-Эрдэнэ /РД:МЮ87081616/ нарт тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



Ц.ОТГОНБАЯР